

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

2024 ОН

ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал (цаашид “аргачлал” гэх)-ын дагуу тооцов.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5-д Монгол Улсын иргэн нь “хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасан.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн үйлчлэх хүрээ гэсэн 3 дугаар зүйлд “энэ хуулийн үйлчлэлд дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь 1 нас хүрсэн, энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан нөхцөлийг хангасан эх” хамаарна гэж заасан бөгөөд мөн хуулийн 3.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан “дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн” гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд хамаарах ба харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй.” гэж заасан.

Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу 6 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Алдарт эх” нэгдүгээр зэргийн одон, 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Алдарт эх” хоёрдугаар зэргийн одонг олгож байгаа бөгөөд ингэхдээ хамгийн бага хүүхэд нь нэг нас хүрэхэд 4 болон 6-аас дээш хүүхэдтэй байсан бөгөөд эдгээр хүүхдийн тоонд 3 хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхдийг хамруулан олгож байна.

Ерөнхийлөгчийн Тамгын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан үзэхэд олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийн нийгмийн халамжийг сайжруулах, “алдарт эх”-ийн одонг авахад дэмжлэг үзүүлэх, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, нийтдээ 4 буюу 6-аас дээш хүүхэд төрүүлж өсгөсөн бөгөөд байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийг хүүхдийн тоонд оруулан тооцож алдарт эхийн одонг олгох зэрэг саналуудыг ирүүлсэн байна.

Төсөлд хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан, эсхүл эсхүл байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхдийг хамруулахаар тусгасан бөгөөд төсөл батлагдсанаар эх, үрсээ дэмжих төрийн бодлого хангагдах нөхцөл бүрдэнэ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн нэгдсэн сангийн төрөлтийн бүртгэлийн мэдээллээс үзэхэд 4 ба 5 хүүхэд төрүүлсэн бөгөөд үүнээс 1 ба түүнээс дээш насандаа нас барсан хүүхэд бүртгүүлсэн эхчүүдийн тоо 8463, 6 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн бөгөөд үүнээс 1 ба түүнээс дээш насандаа нас барсан хүүхэд бүртгүүлсэн эхчүүдийн тоо 1930 орчим байна.

Хуулийн төсөлд байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхдийг хамруулахаар тусгасан.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улсын Их Хурлын 2010 оны “Мөнгөн тусламжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай” 54 дүгээр тогтоолд заасны дагуу "Эхийн алдар" нэгдүгээр зэргийн одонтой эхэд 200000 /хоёр зуун мянган/ төгрөгийн, "Эхийн алдар" хоёрдугаар зэргийн одонтой эхэд 100000 /нэг зуун мянган/ төгрөгийн мөнгөн тусламж жилд нэг удаа олгож байна.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн төслийн хамрах хүрээнд хамрагдан "Эхийн алдар" нэг, хоёрдугаар зэргийн одон авах эхчүүдэд эхийн алдар одон өгөх, одонтой эхэд олгох мөнгөн тусламжид шаардагдах хөрөнгийг төсөвт тусгана.

---oOo---